

Ramanath, J. (2023, 09 26). *The impact of public transport on traffic congestion in cities*. America: Observer Research Foundation. Retrieved from orfonline.org: <https://www.orfonline.org/expert-speak/the-impact-of-public-transport-on-traffic-congestion-in-cities>

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онол арга ТББ. (2022). *Хүүхдэд ээлтэй орчин*. Улаанбаатар.

Ж.Ганчимэг. (2022). *Нийтийн тээврийн чиглэл сайжруулалтын тооцоолол*. Улаанбаатар.

ЖАЙКА. (2022). *Монгол улс Улаанбаатар хотын зам тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх суурь судалгаа*. Улаанбаатар.

Мөнхбат. (2024). *Бодлогын зөвлөмжийг онолын түвшинээр ангилах нь*. Улаанбаатар: МУИС, Бодлогын шинжилгээ хичээлийн лекц SOC601.

МУ Эдийн засгийн хөгжлийн яам. (2023). *Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл*. Улаанбаатар.

МУ-ын Зам тээврийн хөгжлийн яам, А. ү. (2022). *ТӨҮГ-ын үйл ажиллагаанд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайлан*. Улаанбаатар.

НЗДТГ. (2022). *Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалсан судалгааны тайлан*. Улаанбаатар.

НЗДТГ. (2022). *Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалсан судалгааны тайлан*. Улаанбаатар.

НЗДТГ. (2022). *МУ-ын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалсан судалгааны тайлан*. УБ.

(2016). *Нийслэлийн иргэдийн нийтийн тээвэр, хувийн автомашинд хандах хандлагыг судалгаа*. Улаанбаатар.

ННТГ. (2023). *Нийтийн тээврийн газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөө*. Улаанбаатар.

(2018). *Хотын тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр*. Улаанбаатар.

ХХН, Ө. Х. (2023). *Шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийг үнэлсэн байдал*. Улаанбаатар хот: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөн түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн нь.

Цанжид, А. (2023). *Бодлогын тухай ойлголт*. Бодлого судлал: Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Философийн хүрээлэн.

ШУТИС, Бизнесийн ахисан түвшний сургууль, Монгол Улсын Их Сургууль. (2022). *"Нийтийн тээврийн чиглэл сайжруулалтын тооцоолол" зөвлөх үйлчилгээний тайлан*. Улаанбаатар.

НИЙГМИЙН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХИЙСЭН СОЦИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ

Н.Болдмаа,

*МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим доктор, дэд профессор
Orcid:0000-0003-3985-9923*

М.Батбаатар

*МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим доктор, дэд профессор
Orcid:0000-0001-5308-324X*

М.Намуун,

МУИС-ийн ШУС, Ажил мэргэжил судлалын магистрант

Abstract: Supporting the employment of the target group influences overcoming multifaceted social problems (poverty, crime, etc.) and overcoming vulnerability. In today's situation, some progress has been made in the implementation of profiling methodology. As part of the research work, the goal was to clarify employment services for target groups based on qualitative research methodology. According to the results of the study, the target group of citizens is covered by unified services for employment, labor training and support of temporary jobs, however, these groups cannot be provided with specialists dealing with labor issues in a unified and accessible form.

Key words: *tagged group, labour market, service of employment, profiling.*

Оршил

Хөдөлмөр эрхлэлт нь хүн ам хөдөлмөрийн үйл ажиллагаанд оролцохтой холбоотойгоор гарч байгаа харилцааг илэрхийлэгч эдийн засгийн категори бөгөөд хүн ам хөдөлмөрийн үйл явцад хэр зэрэг оролцож байгааг нийгэмд шаардлагатай ажиллагчдын зэрэгцээ, хувийн хэрэгцээний хангамж, ажлын байрны үнэ, ажиллагчдын орлогын түвшин зэргийг хамруулсан ойлголт юм. Хүн амын хөдөлмөр эрхлэлтээс хүмүүсийн амьдралын түвшин хамаардаг ч, боловсон хүчнийг сонгох, бэлтгэх, дахин бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд, тэдний хөдөлмөрийг зохицуулахад, тэрчлэн ажилгүйдэлд өртсөн хэн нэгэнд материаллаг туслалцаа үзүүлэх, нийгмийн зарлагатай ч гэсэн хүн амын нөхөн үйлдвэрлэлийн зайлшгүй нөхцөл юм (Ralph Fevre, 2003).

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг) аргачлалыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiM) төслийн хүрээнд боловсруулсан “Ажилгүй иргэд, ажил хайгчдын төрхийг тодорхойлох, ур чадвараар нь бүлэглэх” арга зүй, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас хэрэгжүүлсэн “Хөдөлмөр эрхлэх цогц ур чадварын хөтөлбөрийн шинэлэг үйлчилгээг турших” хүрээнд хэрэглэгдэж ирсэн “Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ” арга зүйг тус тус ашиглажээ. Аргачлалын үзэл баримтлал нь ажил хайгч, ажилгүй иргэдийн 4 багц асуулгаар үнэлж, үйлчлүүлэгчдийг А,В,С,D гэх 4 үндсэн бүлэгт хуваан хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлэх юм. Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн тогтоолоор /2023.02.03, Дугаар 01/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг (хөтөлбөр)-г баталсан. Уг хөтөлбөр нь нэг талаас тодорхой дэмжлэг, туслалцаа авснаар хөдөлмөрийн зах зээлд шинээр эсвэл дахин оролцох А,В,С бүлгүүдийн хүмүүст гол төлөв зориулагдсан. Нөгөө талаас архины эмгэгтэй, урт хугацаанд ажилгүй байсан (3 ба түүнээс дээш жил), жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн (гэр бүлийн хүчирхийлэл, хүний наймаа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэх мэт), өрх толгойлсон олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, нэн ядуу, ажил хийх хүсэлгүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, алдсан эрх, эрх чөлөөгөө олж аваад удаагүй (шоронгоос суллагдсан) эмэгтэй, эрэгтэй хүмүүс багтах зорилгот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж чадахгүй байна.

Судалгааны зорилго: Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний өнөөгийн байдал, сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны арга зүй. Судалгаанд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин зэргээс хамаарч дараах 5 аймаг/дүүргийн мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Баруун бүсээс Говь-Алтай аймаг,
- Хангайн бүсээс Орхон аймаг,
- Төвийн бүсээс Сэлэнгэ аймаг,
- Баянзүрх дүүрэг,
- Баянгол дүүрэг болно.

Судалгаанд хамрагдсан аймаг/дүүргийн талаарх мэдээллийг ҮСХ-ны 2022 оны статистикийн эмхэтгэл болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 8 сарын мэдээлэлд үндэслэн гаргав.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд

Аймаг/ Дүүрэг	Хүн амын тоо	Ажилгүй хүн		Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	Ажилгүйдлийн түвшин	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
		Нийт	Эмэгтэй			
Говь-Алтай	58,257	3,250	41.1%	502	14.8	51.7
Орхон	106,231	3,495	52.1%	954	9.9	54.7
Сэлэнгэ	107,899	1,827	13.7%	218	7.8	35.9
Баянзүрх дүүрэг	408,797	6,968	31.7%	594	4.8	53.5
Баянгол дүүрэг	246,886	4,578	24.4%	452	5.4	52.4
Улсын дундаж	3,457,500	84,736	40.4%	13,966	6.7	54.7

Эх сурвалж: ҮСХ, ХХҮЕГ, 2022 он

Судалгааны зорилтуудад хүрэхийн тулд зөвлөх (1) баримт бичгийн судалгаа, (2) чанарын судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулан шинжилгээг хийв.

Баримт бичгийн судалгаа. Баримт бичгийн судалгааны хүрээнд хууль, дүрэм журам, статистик тоон мэдээлэл, удирдамж, гарын авлага, судалгааны тайлан, байгууллагын баримт бичгүүд байна.

Чанарын судалгаа. Судалгаанд хамрагдсан аймаг/дүүргийн хөдөлмөр, халамжийн газар/хэлтэсийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэж буй өнөөгийн нөхцөл байдал, D бүлэгт шаардлагатай үйлчилгээ, оролцогч талуудын уялдаа холбоо, үүрэг, санхүүжилт, мэдээлэл солилцоо, тайлагнал, хяналтыг харуулсан зураглалыг хагас бүтэцлэгдсэн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар, D бүлэгт үзүүлж буй нийгмийн ажил, халамж, хөдөлмөр эрхлэлт зэрэг боломжит бүх үйлчилгээг тохиолдлын шинжилгээний аргаар мэдээллийг цуглуулав.

Судалгаанд аймаг/дүүргийн 10 мэргэжилтэнтэй ярилцлагыг хийн 5 тохиолдлын шинжилгээг хийв. Энэхүү судалгааны хүрээнд цугларсан мэдээллийг талбар тус бүрээр нь харьцуулж, гүнзгийрүүлсэн шинжилгээг хийсэн.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл. Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн асуудал хариуцсан 5 мэргэжилтний 4 эмэгтэй, 1 эрэгтэй, насны бүтцийн хувьд 28-52 насны, 3-11 жил, харин аймаг, дүүргийн ГБХЗХГ/ГБХЗХХ-ийн гэр бүлийн хөгжил хариуцсан 5 мэргэжилтний хүйсийн хувьд бүгд эмэгтэй, 27-48 насны, 6 сараас 13 жил хүртэл тухайн ажлын байрандаа ажилласан туршлагатай байна.

1. Үйлчлүүлэгчид суурилсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал

Үйлчлүүлэгчид суурилсан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд дараах үйл ажиллагаа буюу үйлчилгээ, арга хэмжээг хөдөлмөрийн насны хүн ам, зорилгот бүлэгт зориулан тухайн иргэний хэрэгцээнд үндэслэн сонгон хэрэгжүүлэхээр заасан (ХЭҮЗ, 2023). Үүнд:

- 1) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ
- 2) Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа
- 3) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

- 4) *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа*
- 5) *Түүр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа*

Хэдийгээр тогтоолд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болон 5 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан ч аймаг, дүүргүүдийн энэ чиглэлээр гаргасан тайлан мэдээ нэгтгэгдээгүй тул 2022 оны үйл ажиллагааны тайланд тулгуурлан дараах үр дүнг харуулж байна.

Улсын хэмжээнд нийт ажил хайгч иргэдийн 28.8 хувь нь Улаанбаатар хотод байна. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийг хүн амын тоотой харьцуулахад орон нутагт илүү олон иргэн ажил хайгчаар бүртгүүлсэн байна. ХХҮЕГ-ын 2022 оны 12-р сарын мэдээллээр улсын хэмжээнд нийт ажил хайгч иргэдийн 4939 буюу 23,2 хувь нь Баруун бүсэд, 5473 буюу 25,7 хувь нь Хангайн бүсэд, 2398 буюу 11,3 хувь нь Төвийн бүсэд, 2294 буюу 10,8 хувь нь Зүүн бүсэд, 6153 буюу 28,9 хувь нь Улаанбаатарт байна. Харин бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2953 буюу 21,1 хувь нь Баруун бүсэд, 3673 буюу 26,3 хувь нь Хангайн бүсэд, 1373 буюу 9,8 хувь нь Төвийн бүсэд, 1847 буюу 13,2 хувь нь Зүүн бүсэд, 4120 буюу 29,5 хувь нь Улаанбаатар хотод байна. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн мэдээллийг нэгтгэн үзвэл нийт ажил хайгч иргэний 54.2 хувь нь эмэгтэй, нийт бүртгэлтэй ажилгүй иргэний 54.4 хувь нь эмэгтэй байв (ХХҮЕГ, 2023).

Судалгаанд хамрагдсан аймгуудын ХХҮГ/ХХҮХ нь ганцаарчилсан зөвлөгөөнд 6852 иргэнийг хамруулсан бөгөөд 58.9 хувь нь эмэгтэйчүүд байв. Баримт бичгийн шинжилгээгээр улсын хэмжээнд зорилтот бүлгээр ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл авсан 30253, үүнээс 17600 эмэгтэй, харин Зорилтот бүлгээр бүлгийн сургалт, зөвлөгөөний хэлбэрээр ажил, үйлчилгээнд хамрагдсан 62536 иргэн, үүнээс эмэгтэй 32883 байв. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн хувьд 6852 иргэн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсанаас 58.9 хувь нь эмэгтэй, харин 3 аймгийн 4018 иргэн бүлгийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсанаас 54 хувь нь эмэгтэй байна. Эндээс үзэхэд эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүд илүү хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан.

Шигтгээ 1.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсөв маш бага, үүн дотроо ажилд зуучлах үйлчилгээний зардал 36-40%-ийг эзэлдэг. ХБИ-д үйлчилгээ үзүүлэхдээ манай газар лифтгүй учраас нэг давхартаа бууж мэдээлэл зөвлөгөөг өгдөг. Аль болох төрийн үйлчилгээг хүртээмжтэй, үр дүнтэй хүргэхийг зорьж байна.

Орон нутгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Хүснэгт 2. АМЧБО, мэдээллээр хангах үйлчилгээ, судалгааны талбараар

Аймаг/дүүрэг	Ганцаарчилсан зөвлөгөө		Бүлгийн зөвлөгөө	
	Нийт	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй
Орхон аймаг	410	245	1556	865
Сэлэнгэ аймаг	588	334	1638	810
Говь-Алтай аймаг	612	351	824	498
Баянзүрх дүүрэг	3279	1937		
Баянгол дүүрэг	1963	1172		
Бүгд	6852	4039	4018	2173

Зарим аймаг/дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө байхгүй нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ шаардлагын дагуу хүрэхгүй байгааг илтгэнэ.

Судалгаагаар аймаг/дүүргийн ХХҮГ/ХХҮХ-үүд нь 2 аймаг, 1 дүүрэг ганцаарчилсан зөвлөгөөний өрөөтэй, 1 аймаг, 2 дүүрэг бүлгийн сургалтын өрөөтэй, 1 аймаг, 1 дүүрэг нь ХБИ-д зориулсан налуу шаттай, лифттэй нэг ч байгууллага байхгүй. АМЧБО, зөвлөгөө өгөх төлөвлөгөөнийхөө хувьд 73%-80%-ийг эрх бүхий сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг.

Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдэд 2022 оны байдлаар 6667 иргэн ажлын байранд зуучлагдсанаас 53.2 хувь нь эмэгтэй байв. Орон нутагт хамгийн их шинэ ажлын байрыг бий болгосон. Аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ ажлын байрны бүртгэлийг Б-Х33-1 маягтаар, ажил хайгч иргэнийг Б-Х33-2 маягтаар, ажлын байрны захиалгын бүртгэлийг Б-Х33-3 маягтаар тус тус бүртгэн мэдээлийн санд шивж оруулдаг байна. Мэдээлэл цуглуулалтын явцад уг 3 маягт шинэчлэгдэн ирсэн бөгөөд шинэчилсэн маягтаар бүртгэл мэдээллээ хөтөлхөөр төлөвлөж байна. 2022 оны 12-р сарын байдлаар ажил олгогчдоос улсын хэмжээнд нийт 55211 ажлын байрны захиалга ирүүлсэнээс 32290 иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт 59 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 2361 хүнээр буюу 7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн нийт 27390 ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна. Судалгааны талбараар ажлын байранд 6667 иргэн зуучлагдсанаас 53.2 хувь нь эмэгтэй, шинэ ажлын байранд нийт 4910 иргэн орсноос 50.2 хувь нь эмэгтэй байв.

Хүснэгт 3. Ажлын байрны зуучлал болон шинэ ажлын байр, талбараар

Аймаг/дүүрэг	Ажилд зуучлах үйлчилгээ		Шинэ ажлын байр	
	Нийт	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй
Орхон аймаг	1060	685	1081	618
Сэлэнгэ аймаг	1084	473	1220	522
Говь-Алтай аймаг	584	268	1260	493
Баянзүрх дүүрэг	2183	1150	911	560
Баянгол дүүрэг	1756	972	438	275
Бүгд	6667	3548	4910	2468

Орхон аймгийн хэмжээнд 1050 иргэн ажилд зуучлагдсан бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал үйлчилгээний салбарт 38%, барилгын салбарт 20%, уул уурхайн салбарт 13,2%, Зам тээвэр дэд бүтцийн салбарт 0,8%, боловсруулах үйлдвэрт 20%, бусад салбарт 8% тус тус эзэлж байна. Зуучлагдсан иргэдээс байнгын ажлын байранд 718, түр ажлын байранд 94, улирлын ажлын байранд 8 орсон байна. Салбараар нь авч үзвэл үйлчилгээний бусад үйл ажиллагаа болон боловсруулах салбарт хамгийн олон иргэн ажилд зуучлагдсан байна. Баянгол дүүргийн хувьд ажил хайгч 636 иргэнийг байнгын 599, улирлын 5, түр 20, цагийн 12, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Үүнээс үзэхэд орон нутгийн хувьд нэг сард 87-88 иргэн, өдөрт 4-5 иргэн, харин дүүрэгт нэг өдөр 53-54, өдөрт 2-3 иргэн ажлын байранд зуучлагддаг гэсэн үг. Чанарын судалгаагаар ААНБ-ууд ажилд шинээр орсон ажиллагчдынхаа мэдээллийг харьяа аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ-т өгөх байдал удаашралтай, нэлээн их хүчин чармайлтын үр дүнд мэдээллээ авдаг. Энэ нь төрийн болон хувийн хэвшлийн уялдаа холбоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Шигтгээ 2.

Ажил олоход хүндрэлтэй иргэд дүүргийн ХХҮХ-т өөрөө хандсан тохиолдолд Х33-2 маягтыг бөглөж, зөвлөгөө мэдээлэл өгч, аль болох тохиромжтой ажлын байранд зуучилдаг. Харин хэн

нэгнээр дамжуулан хандсан тохиолдолд иргэний утсыг авч, холбогдон уулзалтыг товлодог. Ирсэн үед нь ХЗЗ-2 бөглөн мэдээллийг авч, ярилцлага хийсний үр дүнд ажлын байранд зуучилдаг. Цөөн тохиолдолд ААНБ руу өөрөө хандан ажилд орсон тохиолдол байна. Гэхдээ ихэнх иргэд хэсэг хугацааны дараа ажлаасаа гарсан эсвэл халагдсан байдаг.

Дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Дүүргүүдэд хамгийн их ажлын байрны захиалгыг ирүүлдэг байна. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна. Улсын хэмжээнд 55211 ажлын байрны захиалга ирсэн. Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг, нийслэлд ялгаатай байна. Тухайлбал, аймгийн дунджаар 36 хувьтай байхад нийслэлд 16 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 26 хувьтай байна. Судалгааны үр дүнгээр Улаанбаатар хотын дүүргүүдийн ажлын байрны захиалга орон нутагтай харьцуулахад 3 дахин их байна. Үүнийг ААНБ-уудын дийлэнх нь Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Шигтгээ 3.

Ажлын байрны захиалга ирдэг хэдий ч ажил хийх хүсэл сонирхолтой иргэд жил ирэх тусам буурч байна.

Дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг 463 ажлын байрыг шинээр 23.9 хувь эмэгтэй буюу 5 эрэгтэй тутмын нэг эмэгтэй зээл авсан. Дэлхийн банк Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд гэрээ байгуулсан хугацаанаас хойш Хаан банк, Төрийн банкаар дамжуулан бичил зээл олгогдож 2019-2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1439 иргэнд 12 тэрбум төгрөгийн зээл олгон 2833 ажлын байр бий болсон. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн хувьд 1 тэрбум 928 сая гаруй төгрөгийн зээлийг 210 хүнд олгож, 463 ажлын байрыг шинээр бий болгосон байна. Зээл авсан иргэдийн 23.9 хувь нь эмэгтэй байв.

Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн 4178 иргэн хөдөлмөрт эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан. Хөтөлбөрүүдэд гол төлөв амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, ажил олоход хүндрэлтэй, ХБ-тэй залуучууд, эрэгтэй, эмэгтэй хамруулсан. Хөдөлмөр бэлтгэх хөтөлбөрт 2022 оны 12-р сарын тоон мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд 16018 иргэн хамрагдаж, 2875 иргэн ажлын байраар хангагдсан байна. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн хувьд 2465 иргэн ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт, ажилд зуучлах уулзалтад бэлтгэх сургалт болон танхимийн сургалтад хамрагдсан болно. Харин үйлдвэр дээрх сургалт болон нийгмийн хариуцлагатай олгогчийг шалгаруулах үйл ажиллагаа хэрэгжээгүй байна.

Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2022 оны 12-р сарын байдлаар нийт 11869 иргэн хамрагдаж 21,345,691,899 төгрөг зарцуулж 4377 ажлын байр бий болсон байна.

Өнөөгийн байдлаар бүтцийн өөрчлөлт удаашралтай, өмнөх тогтсон арга барилаар ажиллаж буй нийтлэг дүр төрх харагдсан. Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь АМЧБО, зөвлөгөө өгөх, зуучлах үйлчилгээ, хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих үйлчилгээг нэгэн зэрэг хариуцахаар төлөвлөж байгаа ч ажлын байрны тодорхойлолт эцэслэгдээгүй, бүтцийн өөрчлөлт эхлэл төдий, хүний нөөц, чадавх, хүн амын тоо зэргээс шалтгаалан дараах байдлаар үйлчилгээг үзүүлж байна. Тодруулбал,

- ХЗЗ-2 болон зарим тохиолдолд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайланг)-д суурилан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон ажилд зуучлах (ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийг бүртгэх);
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа;

Шигтгээ 4.

Багийн хувьд хүн амын тоо их, иргэд гол төлөв халамжийн үйлчилгээ авах зорилгоор ирдэг. Ажлын ихэнх цагийг иргэдийн халамжтай холбоотой асуудлыг шийдэхэд зарцуулж байна. Иргэн ажил эрхлэлтийн зөвлөгөө авахаар ирэхэд тусгайлсан өрөө байхгүй, одоо үйл ажиллагаагаа явуулж буй өрөөндөө уулзахаар хүмүүс ороод ирдэг, гэнэт тайлан, мэдээ хэрэгтэй болдог гээд нөгөө үйлчлүүлэгчээ орхиход хүргэдэг. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний (профайлинг) арга зүйн сургалтад хамрагдсан. Ажлынхаа ачааллыг харж байгаад сард 2-3 профайлинг хийж байна.

Орон нутгийн ХЭХА хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Эндээс үзэхэд Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөл, ХНХЯ болон ХХҮЕГ-аас өгсөн удирдамж, чиглэлүүд тодорхой гарсан ч практикт хэрэгжилт хангалтгүй байна. Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэхэд аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь сум, хорооны ХЭХА хариуцсан мэргэжилтэн, ТББ, мэргэжлийн холбоодын (ахмадын холбоо, ХБ-тэй иргэдийн холбоо гэх мэт) уялдаа холбоо сайн, харин бусад газар, хэлтэст, ААНБ хамтран ажиллах байдал хангалтгүй, сул байна.

2. Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлж буй өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ

Судалгааны үр дүнд суурилан зорилтот бүлгийн иргэдэд тулгарч буй асуудлаас хамаарч архины хамааралтай, хорих ангиас суллагдсан, амьжиргааны баталгаажих түвшний доогуур, ядуу, асрамжийн газарт хүмүүжсэн, сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнийг асардаг, хүчирхийлэлд урт хугацаанд өртсөн иргэдийг багтааж ойлгоно. Аймаг, дүүргийн хувьд бүх зорилтот бүлгүүдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг жигд хүргэж чадахгүй байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд ажил олоход хүндрэлтэй байгаа дараах иргэдийг зорилтот бүлэгт (n=9) хамруулж болох юм. Тухайлбал,

1. Донтох эмгэгтэй иргэд (архины, мансууруулах, тоглоом, дэлгэц, сэтгэцэд нөлөөлөх эм бодис бэлдмэл гэх мэт)⁴⁶;
2. Хорих ангиас суллагдсан иргэд⁴⁷;
3. Амьжиргааны баталгаажих түвшний доогуур, ядуу өрхийн гишүүн (хүнсний эрхийн бичиг авдаг)⁴⁸;

⁴⁶ Өөрийгөө хянах хяналтаа алдан, давж гаршгүй ямар нэгэн зүйлд татагдсан эсвэл автагдсан хүнийг хэлнэ.

⁴⁷ Хорих ангид ял эдлэн, суллагдсан этгээдийг хэлнэ. Хорих ангийн дэглэмийг нээлттэй болон хаалттай гэж ангилдаг.

⁴⁸ Хүн амын амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой, хүнсний эрхийн бичиг авдаг өрхийг хэлнэ

4. Асрамжийн газраас гарсан иргэн⁴⁹;
5. Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн⁵⁰;
7. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч буй иргэн
8. Урт хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн
9. Бүрэн бус дунд боловсролтой, мэргэжил эзэмшээгүй 45 ба түүнээс дээш насны иргэн болно.

Зорилтот бүлгийн иргэдийг илрүүлэхдээ баг, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээс судалгааг авах, зарим тохиолдолд аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд өөрсдөө судалгаа хийх, иргэн өөрөө биечлэн ирэх эсвэл хэн нэгний тусламжтайгаар хандсан иргэдтэй холбогдон уулзалтын цагийг товлодог. Судалгаанд хамрагдсан орон нутгийн тухайд гол төлөв амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй болон архины донтох эмгэгтэй иргэнтэй ярилцлага хийх замаар Б-Х33-2 маягтыг бөглөж, цөөн тохиолдолд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-гээр тодорхойлж, мэдээлэл өгсний дараа ажилд зуучлах үйлчилгээг үзүүлэхийг зорьж байна. Гэхдээ хөдөлмөр хариуцсан мэргэжилтнүүдийн D бүлгийг тодорхойлоход ойлголт мэдлэг сул, хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-д суурилан хувийн төлөвлөгөөг гарган үр дүнтэй үйлчилгээ үзүүлж буй туршлага судалгаанд хамрагдсан талбаруудад гарсангүй.

Судалгааны ажлын хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хэрхэн хүргэж буйг доорх хүснэгтүүдэд дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 8. Донтох эмгэгтэй иргэдэд (архины, мансууруулах, тоглоом, дэлгэц, сэтгэцэд нөлөөлөх эм бодис бэлдмэл гэх мэт) үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ

№	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ	Архинд донтолт	Хорих ангиас суллагдсан иргэд	Хүнсний эрхийн бичиг авдаг өрхийн гишүүн	Асрамжийн газраас гарсан иргэд	Сургууль завсардсан иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ							
1	Бүртгэх (Б-Х33-2, профайланг)	+	+	+	+		+
2	АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	+	+	+	+	+	+
3	Ажилд зуучлах	+	+	+			+
4	Ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийг бүртгэх		+				
5	Нэгдсэн бүртгэл мэдээллийн хамруулах		+		+		
Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа							
1	Суурь ур чадварын сургалт	+	+				+
2	Залуучуудын сургалт, зөвлөгөө				+		+
Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа							
1	Мод тарих	+	+		+		+
2	Нийтийг хамарсан ажил	+	+				+
3	Ажилд зуучлах		+				

⁴⁹ Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг авсан насанд хүрсэн иргэнийг хэлнэ.

⁵⁰ Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа						
1	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт					+

Дээд дурдсан бүлгүүдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг гол төлөв хүргэж байгаа бөгөөд ажилд зуучилсан ч төдийлэн тогтвор суурьшилтай ажилладаггүй талаар мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харагдаж байсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад Баянзүрх дүүрэг болон Орхон аймаг архины хамааралтай, донтох эмгэгтэй иргэдэд зориулсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. Тодруулбал, Баянзүрх дүүргийн хэмжээнд орон гэргүй, архины хамааралтай иргэдийг цуглуулж, тэднийг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Нийт 80 иргэнийг шалгаруулж, “Шижир” амралтад байрлуулан 60 хоногийн турш нөхцөл байдлаа даван туулахад чиглэгдсэн нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг өгсний дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. Орхон аймгийн тухайд 2023 оны 7-р сарын 20 өдрөөс 11 сарын 15 хүртэл “Алхам алхмаар” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн зорилго нь архины болон хортой хэрэглээний асуудлаа шийдэхийг хүссэн Орхон аймгийн харьяат 20 иргэнийг сайн дурын үндсэн дээр сонгон авч, гэр бүлийн гишүүдийн хамт сэтгэл зүй, сэтгэл санааны эмчилгээний хөтөлбөрт хамруулсан. Уг үйл ажиллагааг ГБХЗХГ, ЗДТГ, ХХҮГ хамтран хэрэгжүүлэх ба нийт 10,200,000 төгрөгийг төсөвлөсөн байна (ГБХЗХГ, 2023). Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат, төлөвлөгөөнд архины хамааралтай иргэн, түүний гэр бүлийн гишүүдэд хамтад нь үйлчилгээ үзүүлж байгаагаар онцлог юм. Архины хамааралтай иргэн эрүүл мэнд, нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө авсны дараа хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг авахаар төлөвлөсөн нь хөтөлбөрийг үр дүнтэй болгоход нөлөөлнө. Энэ нь нийгмийн ажлын үйлчилгээ суурьтай хөдөлмөрийн эрхлэлтийн үйлчилгээг үзүүлснээр зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, ингэснээр амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтой гэж үзэж байна.

Зорилто бүлгийн иргэдийн (профайлангаар D бүлэг гэж тодорхойлох) хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд нийгмийн ажлын үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний уялдааг хангах зайлшгүй шаардлагатай байна.

Дүгнэлт, зөвлөмж

- Улсын хэмжээнд нийт ажил хайгч иргэдийн 28.8 хувь нь Улаанбаатар хотод байна. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн хувьд Орхон аймаг илүү олон иргэн ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Судалгаанд хамрагдсан аймгуудын ХХҮГ/ХХҮХ нь ганцаарчилсан зөвлөгөөгнд 6852 иргэнийг хамруулсан бөгөөд 58.9 хувь нь эмэгтэйчүүд байв. Зарим аймаг/дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө байхгүй нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ шаардлагын дагуу хүрэхгүй байгааг илтгэнэ. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдэд 2022 оны байдлаар 6667 иргэн ажлын байранд зуучлагдсанаас 53.2 хувь нь эмэгтэй байв. Орон нутагт хамгийн их шинэ ажлын байрыг бий болгосон. Судалгаанд хамрагдсан Баянзүрх, Баянгол дүүргүүдэд хамгийн их ажлын байрны захиалгыг ирүүлсэн. Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 463 ажлын байрыг шинээр 23.9 хувь эмэгтэй буюу 5 эрэгтэй тутмын нэг эмэгтэй зээл авсан.
- Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн 4178 иргэн хөдөлмөрт эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан. Хөтөлбөрүүдэд гол төлөв амьжиргааны баталгаажих түвшингээс

доогуур орлоготой, ажил олоход хүндрэлтэй, ХБ-тэй залуучууд, эрэгтэй, эмэгтэй хамруулсан.

- Эрх зүйн зохицуулалтаар хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд үйл ажиллагаагаа үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлэхээр тусгасан ч өнөөгийн байдлаар өөрчлөлт удаашралтай, өмнөх тогтсон арга барилаар ажиллаж буй нийтлэг дүр төрх харагдсан. Өөрөөр хэлбэл, АМЧБО, ажилд зуучлах, ажилгүйдлийн тэтгэмжийг 1-2 мэргэжилтнүүд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг 2-3 мэргэжилтнүүд хариуцан ажилладаг.
- Судалгааны үр дүнд суурилан зорилтот бүлэгт тулгарч буй асуудлаас хамаарч архины хамааралтай, хорих ангиас суллагдсан, амьжиргааны баталгаажих түвшний доогуур, ядуу, асрамжийн газарт хүмүүжсэн, сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнийг асардаг, хүчирхийлэлд урт хугацаанд өртсөн иргэд, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжил эзэмшээгүй 45 ба түүнээс дээш насны иргэдийг багтааж ойлгоно. Аймаг, дүүргийн хувьд нийгмийн зорилтот бүлгүүдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй хүргэж чадахгүй байна.
- Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн зорилтот бүлгийн (D бүлэгт багтсан) талаарх ойлголт мэдлэг сул, үр дүнтэй үйлчилгээ үзүүлж буй туршлага бараг судалгаанд хамрагдсан талбаруудад гарсангүй.

Ашигласан материалын жагсаалтууд

1. Монгол Улсын Засгийн газар, Европын Холбоо. (2023) *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ*. Би Си Ай ХХК., Улаанбаатар.
2. Орхон аймгийн ГБХЗХГ. (2023) *Алхам алхмаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж*. Орхон аймаг.
3. Д.Түмэнзул. (2015) *Архины хамааралтай хүмүүстэй ажиллах нийгмийн ажлын арга зүй ба технологи: магистрын ажил*, МУИС. Улаанбаатар.
4. УИХ. (2021) *Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>
5. УИХ. (2016) *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11711>
6. УИХ. (2016) *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12393>
7. ҮСХ, *Хүн амын амьжиргааны доод түвшин, бүсээр*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758238981791&showType=1>
8. УИХ. (2012) *Нийгмийн халамжийн тухай /шинэчилсэн найруулга/*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/393>
9. ҮСХ, UNFPA, UNICEF. (2018) *Монгол улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа*, Улаанбаатар.
10. ХНХЯ. (2021) *Хөдөлмөрийн хувийн биржүүд*. Улаанбаатар. Retrieved from https://mlsp.gov.mn/uploads/files/Hudulmur_hubiin_birjuud.pdf
11. ХНХЯ. (2021) *Хөдөлмөрийн хувийн биржүүд*. Улаанбаатар. Retrieved from https://mlsp.gov.mn/uploads/files/Hudulmur_hubiin_birjuud.pdf
12. ХХҮЕГ. (2023) *Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал-2022*, Улаанбаатар.

13. ХЭҮЗ. (2022) *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөрийг батлах тухай*. Улаанбаатар. Retrieved from <https://mlsp.gov.mn/uploads/files/hutulbur2022.pdf>
14. ШШГЕГ. (2023) *Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын статистик мэдээлэл*. Улаанбаатар Retrieved from <https://uzesgelen.cd.gov.mn/wp/>
15. Ralph Fevre. (2003). *The Sociology of Labour Markets*. University College of Swansea.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Л. Сарангэрэл. Доктор

МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш

Abstract: *The purpose of this article is to study concept, theory, basic principles of the child friendly city, and comparing international experiences between their indicators. The theoretical framework of a child-friendly city is based on the idea that changes in city policy, planning and activity will lead to changes in the lives of children. In particular, the cities of underdeveloped and developing countries face a wide range of problems related to Children's Rights, safety and their environment.*

Keywords: *Child friendly city, theory of Change, Children's Rights, safety, environment, influencing city decisions, participation in social life and family, access to basic services such as health, education, housing.*

Хүүхдэд ээлтэй хотын тухай ойлголт нь НҮБ-ийн 1992 оны хүүхдийн эрхийн конвенцоос эх үндэстэй (UNICEF, 1992). 1996 онд Туркийн Истанбулд “Хүүхдэд ээлтэй хотууд” санаачлага анх эхэлсэн байдаг. Дэлхийн улс орнууд хүүхдэд ээлтэй хот, орон нутгийг бий болгох санаачлагыг сүүлийн жилүүдэд идэвхтэй дэмжиж байна. Ялангуяа буурай хөгжилтэй болон хөгжиж орнуудын хотын өмнө хүүхдийн эрх, аюулгүй байдал, орчинтой холбоотой өргөн хүрээтэй олон асуудлууд тулгамдаж байна.

Хүүхдэд ээлтэй хотын талаарх үзэл баримтлалыг ойлгохын тулд онолын түвшинд судлах ёстой. Онолын суурь нь бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийснээр хүүхдийн амьдралд өөрчлөлт гарна гэсэн онолын үзэл дээр тулгуурладаг.

Зураг 1. Хүүхдэд ээлтэй хот: Өөрчлөлтийн онол